



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/708

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалын нийтлэг журам-ын 2.1.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019-2020 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд хил залгаа гадны аймгуудын сумдуудтай гэрээ хэлцэл байгуулах, төрийн үйлчилгээг тухайн сумдаас авахуулах, оторт яваа малчидтай уулзаж газар дээр нь танилцах ажил зохион байгуулахыг "Аймгийн отрын штаб" (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 3880500 (гурван сая найман зуун наян мянга таван зуу) төгрөгийг "Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101337